



2021 оны 07-р сарын 06-ны өдөр

Дугаар: PFG2021070600002

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ-Д

Гүйцэтгэлийн баталгаа гаргах тухай

УБ ХУД 3-Р ХОРОО RIVER STONE 26A-108TOOT хаягт орших 5462789 тоот регистрийн дугаартай БОДИТ ЧАДАЛ ХХК ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь БХБЯ/202103125 БХБЯ/202103125 Улаанбаатар хотод шинээр барих 110кв дэд станцуудын зураг төсөл/Дамбадаржаа, Ихнаран/ (цаашид "Гэрээ" гэх) ажлыг гүйцэтгэх болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрхи гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

"ХААН Банк" ХХК буюу түүнийг төлөөлж ХУД 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Т-Ноос ХХК-ны байр хаягт орших Үйлдвэр комбинат тооцооны төвийн Тооцооны төвийн захирал Пүрвээ Жавхлан (цаашид "Банк" гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс 8,944,100.00 Төгрөг (Найман сая есөн зуун дөчин дөрвөн мянга нэг зуун төгрөг)-с хэтрэхгүй мөнгөн дунтэй төлбөрийг Барилга хот байгуулалтын яам (Цаашид "Захиалагч" гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурьдсан 8,944,100.00 Төгрөг (Найман сая есөн зуун дөчин дөрвөн мянга нэг зуун төгрөг)-н хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний баримт бичигт оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрхи өөрчлөлт, нэмэлтийн талаар аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Үйлдвэр комбинат тооцооны төв

Тооцооны төвийн захирал / Пүрвээ Жавхлан /



119823

* Баталгааны хүчин төгөлдөр байдлын талаар албан тоотын баруун дээд булаанд байрлах цахим хаяг болон утсаар холбогдон баталгаажуулна уу.
Баталгаажуулаагүйн улмаас үүдэн гарах аливаа хариуцлагыг банк хүлээхгүй болно.

**“УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИХ 110 КВ-ЫН ДЭД СТАНЦУУДЫН ЗУРАГ
ТӨСӨЛ /ДАМБАДАРЖАА, БАЯНХОШУУ, ИХ НАРАН/ БОЛОВСРУУЛАХ” АЖЛЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭЭР ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)

Улаанбаатар
2021 он
БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

БАРИЛГА ХОТ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


С.МАГНАЙСҮРЭН


Б.НАСАНТОГОХ

ГҮЙЦЭТГЭГЧ:

"БОДИТ ЧАДАЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


БОДИТ ЧАДАЛ
ХХК

С.БАТХҮРЭЛ

**"УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИХ 110 КВ-ЫН ДЭД СТАНЦУУДЫН ЗУРАГ
ТӨСӨЛ /ДАМБАДАРЖАА, БАЯНХОШУУ, ИХ НАРАН/ БОЛОВСРУУЛАХ" АЖЛЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭЭР ЗАХИАЛАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

2021 оны 07 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар: 2021/232

Улаанбаатар хот

Нэг талаас Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Бодит чадал" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу зөвлөх үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих "УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИХ 110 КВ-ЫН ДЭД СТАНЦУУДЫН ЗУРАГ ТӨСӨЛ /ДАМБАДАРЖАА, БАЯНХОШУУ, ИХ НАРАН/ БОЛОВСРУУЛАХ" ажлын зөвлөх үйлчилгээг – 178 882 000 (Нэг зуун далан найман сая найман зуун наян хоёр мянга) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: 178 882 000 (Нэг зуун далан найман сая найман зуун наян хоёр мянга) төгрөг.

Үүнээс: Улсын төсвөөс: 2021 онд: 125,217,400 (Нэг зуун хорин таван сая хоёр зуун арван долоон мянга дөрвөн зуу) төгрөг

2022 онд: 53,664,600 (Тавин турван сая зургаан зуун жаран дөрвөн мянга зургаан зуу) төгрөг

4. Гүйцэтгэгч нь "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих "УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИХ 110 КВ-ЫН ДЭД СТАНЦУУДЫН ЗУРАГ ТӨСӨЛ /ДАМБАДАРЖАА, БАЯНХОШУУ, ИХ НАРАН/ БОЛОВСРУУЛАХ" ажлын зөвлөх үйлчилгээг 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр эхэлж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 5.3 Тендер;
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;

- 5.6 Техникийн тодорхойлолт;
- 5.7 Зураг;
- 5.8 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
- 5.9 Санхүүжилтийн хуваарь;
- 5.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол ёгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга “Бодит чадал” ХХК-ийн Зургийн инженер

Э.ГАНХҮҮ
А.ЭНХБАТ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Б.БАТ-ЭРДЭНЭ

Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Эрчим хүчний яамны ТЗҮГ-ын Хуулийн хэлтсийн дарга “Бодит чадал” ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

С.ДОЛЖИНСҮРЭН

Л.МОНХЖАРГАЛ

Б.НАНДИНЧИМЭГ

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга ~

Б.НЯМДОРЖ

Я.НЯМЖАРГАЛ

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ЫН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТХҮҮ

Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, Барилгачдын талбай-
3, Засгийн газрын 12 дугаар
байр

Утас: +976 76003333
Факс: +976 0322904

Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг 3-р хороо, Засгийн
газрын XIV байр, өргөтгөл

Эрчим хүчний яам, Эрчим
хүчний хөгжлийн төв

Утас: 62263051, 77116050

Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг, 3-р хороо, Ривер
Стоун хотхон 26а байрны
108 тоот

Утас: 88075492, 76015492

Харилцах дансны дугаар:
Хаан банк 5031351537
Дансны нэр: Бодит чадал
ХХК

II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1.1 Нэр томъёоны тайлбар	1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
	(а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
	(б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
	(в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
	(г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
	(е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
	(д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
	(е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцлийг хэлнэ.
	(ё) “Гишүүн” гэж түншлэл /консорциум/ холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
	(ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
	(з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлсөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
	(л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцлийг хэлнэ.
	(м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
	(о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
	(ө) “Ажиллах хүчин ” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.
1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль	Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.

1.3 Гэрээнд ашиглах хэл	Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
1.4 Мэдэгдэл	Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдаа аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстай. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстай.
1.5 Байршил	Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстай.
1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ	Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бурдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч	Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
1.8 Татвар, хураамж	Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстай.
1.9 Авиалгал болон залилан мэхлэх үйлдэл	Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстай. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авиалгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авиалгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сурдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох	Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан. Эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
2.2 Үйлчилгээг эхлэх	Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстай.

2.3	Гэрээний хугацаа дуусгавар болох	ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
2.4	Гэрээний өөрчлөлт буюу засвар	Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
2.5	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл	<p>2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.</p> <p>Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.</p>

2.6 Гэрээ цуцлах

- 2.6.1** Захиалагч гэрээг цуцлах
- Энхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй:
 - (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
 - (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
 - (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
 - (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шиндвэрлэсэн үүл:
 - (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:

2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах	<p>Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй</p>
	<ul style="list-style-type: none"> (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон: (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй: (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй:
2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр	<p>ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:</p>
	<ul style="list-style-type: none"> (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс: (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:
3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	
3.1 Ерөнхий зүйл	
3.1.1 Гүйцэтгэлийн чанар	<p>Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.</p>
	<p>Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.</p>
3.2 Ашиг сонирхлын зөрчил	<p>Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих</p>

		ёстай бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстай.
3.3 Нууцлал		Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй
3.4 Зөвлөхийн хариуцах даатгал		Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа		Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстай. Үүнд:
	(а)	Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
	(б)	Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
	(в)	ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
3.6 Тайлагнах хуваарь		Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хургуулэх ёстай.
3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь		Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсаналиваа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө здгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хургуулнэ. Зөвлөх нь здгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит		Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах nyaгтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

4.1 Ажиллах хүчиний тодорхойлолт	Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.
4.2 Ажилтныг халах буюу солих	(а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчиний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү

буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.

- (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох	Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.
5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт	Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиолцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.
5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө	Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

6.1 Нийт төлбөр	Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
6.2 Гэрээний үнэ	(а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно. (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр	ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.

6.4 Төлбөр хийх нөхцөл.хуваарь

Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.

ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстай.

6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү

Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстай.

7. ШУДАРГА БАЙДАЛ

7.1 Шударга байдал

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх

Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2 Маргааныг шийдвэрлэх

Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	<p>Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.</p>
{1.1(a)}	<p>Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}</p>
1.3	<p>Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.</p>
1.4	<p>Захиалагч: Барилга, хот байгуулалтын яам Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр, Харилцах хүн: Барилга, хот байгуулалтын яамны Хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Орхонбаяр, Утас: 99017228 Захиалагч: Эрчим хүчний яам Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14 дүгээр байр, Харилцах хүн: Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч П.Жаргалсайхан, Утас: 88093049 Захиалагчийн хяналт гүйцэтгэгч: “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр, Харилцах хүн: “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиалагч, хяналтын хэлтсийн дарга Л.Батхүү, Утас: 80110503 Зөвлөх: “Бодит чадал” ХХК Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ривер стоун хотхон 26а байр 108 тоот Харилцах хүн: “Бодит чадал” ХХК-ийн Захирал С.Батхүрэл, Утас: 88075492, И-мэйл: Batkhurel@realpower.mn</p>
1.7	<p>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид: Захиалагчийн: Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Дулмаа, Утас: 8811-9798, Захиалагчийн хяналт гүйцэтгэгч: “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиалагч, хяналтын хэлтсийн ахлах инженер Ш.Шижирбат, Утас: 88334579, Зөвлөхийн: “Бодит чадал” ХХК-ийн Зургийн инженер Л.Ичинхорлоо, Утас: 99463337, 76015492</p>

1.8	Татвар: Зөвлөх нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамж, шимтгэлийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна. Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд хуулийн дагуу төлөх татвар, даатгал, хураамж, баатсан байна.
2.2	Тогтоосон хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс эхэнэ.
2.3	Тогтоосон хугацаа: Зургийн даалгаварт заасан хугацаа /2022 оны 01-р сарын 20-ны өдөр/ дуусна.
{3.5 (в)}	Бусад үйл ажиллагаа: Захиалагч нь Зураг төслийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, техникийн нөхцөл гаргуулах, магадлалаар хянуулах зэрэг ажилд зөвлөхөд дэмжлэг, туслалцаа үзүүлж холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: 178 882 000 /Нэг зуун далан найман сая найман зуун хоёр мянга/ төгрөг
6.4	<p>Төлбөр хийх данснууд: ХААН Банк, 5031351537 /Бодит чадал ХХК/</p> <p>Төгрөгийн хувьд: 178 882 000 (Нэг зуун далан найман сая найман зуун хоёр мянга) төгрөг</p> <p>Төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө.</p> <p>Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь харилцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө.</p> <p>a) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх 53,664,600 / Тавин гурван сая зургаан зуун жаран дөрвөн мянга зургаан зуун/ төгрөгийг эхлэлийн шатны тайланг хүлээн авч эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурснаар төлнө. Эхлэлийн шатны тайлан дараах бүтэцтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотод шинээр барих 110 кВ-ын дэд станцууд /Дамбадаржаа, Баянхшуу, Их наран/, ЦДАШ-ын судалгааны ажлыг эхлүүлсэн тухай тайлан - 110 кВ-ын ЦДАШ-ын трасс гаргах - Холбогдох инженерийн байгууллагуудаас тодруулга авч зөвшилцөх <p>b) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх 71,552,800 /Далан нэгэн сая таван зуун тавин хоёр мянга найман зуу/ төгрөгийг дунд шатны тайланг хүлээн авч эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурснаар төлнө. Дунд шатны тайлан дараах бүтэцтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Инженер геодезийн ажлын тайлан - Инженер геологийн ажлын тайлан <p>c) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх 53,664,600 / Тавин гурван сая зургаан зуун жаран дөрвөн мянга зургаан зуун/ зураг төслийг экспертизээр хянахдан хүлээн авсны дараа олгоно.</p>
36.5	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. Нийт гэрээний үнийн 10%-иас хэтрүүлэхгүй
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ажил гүйцэтгэх хугацаа, график

**"Улаанбаатар хотын Дамбадаржаа, Баянхошуу, Ихнаран орчимд шинээр барих
110 кВ-ын ЦДАШ, 2x40 МВА хүчин чадалтай дэд станцууд"-ын зураг төсөл
боловсруулах ажлын төлөвлөгөө**

#	Хийх ажлын нэр	Сарууд											
		1 дахь сар		2 дахь сар		3 дахь сар		4 дэхь сар		5 дахь сар		6 дахь сар	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ажлын зураг төсөл, боловсруулах													
1	Геодизийн хэмжилт												
2	Геологийн хэмжилт												
3	110 кВ-ын ЦДАШ-уудын ажлын зураг												
4	Дамбадаржаа дэд станцын зураг												
5	Баянхошуу станцын зураг												
6	Ихнаран станцын зураг												
7	Дэд станцын өргөлийн зураг												
8	Барилгын зураг												
9	Төсөв												
10	Эксперт, батлуулах												



Бэлгэсэн инженер:

П.Ичинхорллоо